- Зорчигчдын аялалын хугацааг тодорхойлдог зүйлсийн нэг болох хөдлөх бүрэлдэхүүний стандарт хурд нь метроны буудал хоорондын зайн ойрхон байх тусам буурдаг тул зогсоол хоорондын зайн бага зэрэг холдуулан төлөвлөх шаардлага гардаг. Хоорондын зайн холдвол зорчигчдод ойр үйлчлэх зарчимд сөргөөр нөлөөлдөг.
- Өдөр тутамын хэрэгцээний тээврийн хэрэгсэл тул зорчигчдод аль болох ойр байж хүртээмжтэй үйлчилгээг үзүүлж байж олон хэрэглэгчтэй болох боловч метроны буудал хоорондын зайн ойрхон байх тохиолдолд зорчих хэрэгцээний хүрээ давхцаж үр ашиг багасдаг учир ойролцоо метроны буудалтай тээвэрлэлтийн үр ашигтай хуваарилалт бий болохуйц зайн хэмжээг тооцох хэрэгтэй.

- Газар доорхи бүтээцээр ихэнх хэсэг нь бүрддэг метроны буудлын барилгын ажлын өртөг нь газар шорооны ажлын хэмжээнээс шалтгаалдаг боловч буудал хоорондын зайн ойртох тусам барилгын өртөг өсөж, холдох тусам буурдаг.
- Метроны буудал хоорондын зайнас хамаарах ①хөдлөх бүрэлдэхүүний хүчин чадал, ②хуваарыт хурд, ③зорчигдлын хүрээ, ④барилгын өртөг зэргийг тооцон зохимжит зайн хэмжээг тодорхойлох шаардлагатай.

[хүснэгт 4.6.2] Метроны буудал хоорондын зайн нөлөөлөл

Ангилал	Метроны буудал хоорондын зайн		Тайлбар
	Ойр	Хол	
Хөдлөх бүрэлдэхүүний хүчин чадал(ашиглалтын үр ашиг)	ашиггүй	ашигтай	
Хуваарыт хурд(хугацаа богиносох)	ашиггүй	ашигтай	
Буудлын зорчигчдын хүрээ(ойрхон байх)	ашигтай	ашиггүй	
Төслийн өртөг(зардал)	ашиггүй	ашигтай	

### (3) Барилгын өртөгийн нөлөөлөл

- Метроны барилгын ажлын өртөгийг зам төмрийн ба метроны буудлын гэж хувааж болно. Метроны буудлын барилгын ажлын өртөгт газар шорооны ажлаас гадна барилга архитектур, техник тоног төхөөрөмжийн зардуулд багтдаг тул метроны буудал хоорондын зайн ойролцоогоор 1км байх метроны буудлын барилгын өртөг нь метроны нийт өртөгт харьцуулахад нэлээд өндөр болно.
- Метроны буудал хоорондын зайн ойр байх тусам өртөг ихэсдэг, холдох тусам буурдаг шалтгааныг судлан дараах хүснэгтээр үзүүллээ. Метроны буудал хоорондын зайн 1км-ээс их байх тусам барилгын нэгж өртөгт үзүүлэх нөлөөлөл багасаж байгааг харьцуулсан судалгаагар тогтоосон.

[хүснэгт 4.6.3] Метроны буудал хоорондын өртөгийн харьцангуй харьцаа

Метроны буудал хоорондын зайн(м)	Барилгын өртөг харьцангуй харьцаа(%)	Тайлбар
600	132	
800	112	
1,000	100	
1,200	94	
1,300	92	

Тайлбар) Харьцангуй харьцаа нь метроны буудал хоорондын зайн 1,000м байх үеийн барилгын өртөгийн харьцангуй харьцаа болно.


### (4) Метроны буудал хоорондын дундаж зайд тооцох

- БНСУ-ын метроны буудал хоорондын дундаж зайн нь 1.260км бөгөөд метроны бүтээн байгуулалтын үед энэ зайн 1.0км байх нь хамгийн тохиромжтой хэмээн үзэж байсан байна.
- УБ хотын метроны буудал хоорондын зайн оновчтой тогтоохын тулд ①хөдлөх бүрэлдэхүүний хүчин чадал, ②хуваарыт хурд, ③буудлын зорчигдлын хүрээ, ④барилгын өртөг зэргийг харгалзан тооцсон ба хотын төвийн ба захын хуваарыт хурдыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд ойрхон, хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, барилгын ажлын зардлыг зохих түвшинд барьсан гэж үзэж байна.

[хүснэгт 4.6.4] Төслийн метроны буудал хоорондын дундаж хэмжээ/зай/

Ангилал	Нийт урт (км)	Метроны буудал (газар)	Буудал хоорондын дундаж зайн(км)	Хуваарыт хурд (км/цаг)	Тайлбар
МЕТРОНЫ ШУГАМ-1	28.38	21	1.351	34.94	
МЕТРОНЫ ШУГАМ-2	21.03	14	1.502	41.85	
Нийт	49.41	35	1.412	37.58	

## 4.6.3 Метроны хэвтээ, босоо тэнхлэгийн шугамын буудлуудын байршил












## 4.7 Метроны буудлын хүлээн авах явуулах замын төлөвлөлт

### 4.7.1 Метроны 1-р шугамын буудлын бүтээцийн хувилбар тус бүрээр хүлээн авах явуулах замын төлөвлөлт

Ангилал	Зорчих тавцан 2 талдаа	Зорчих тавцан голдоо	Дамжин зорчих буудал
Хүлээн авах, явуулах замын зураг			
Газар доорх буудал			
	107, 108, 111, 112, 114, 115, 116, 118 буудлууд	109, 113, 117 буудал	110 буудал
Гүүрэн дээрх буудал			
	105, 119 буудал	102, 103, 104, 106, 120 буудал	101 буудал
Газар дээр ил метроны буудал			
	-	-	121 буудал


Метроны буудлын уртыг хэтдээ нэг цуваанд 6 хөдлөх бүрэлдэхүүн байхаар тооцож 110 м-ийн урттайгаар төлөвлөсөн.

#### 4.7.2 Метроны 2-р шугамын буудлын бүтээцийн хувилбар тус бүрээр хүлээн авах явуулах замын төлөвлөлт

Ангилал	Зорчих тавцан 2 талдаа	Зорчих тавцан голдоо	Дамжин зорчих буудал
Хүлээн авах явуулах зам			
Газар доорх буудал			
	201, 202, 209, 210, 211, 213 буудал	207, 208, 212 буудал	214 буудал
Гүүрэн дээрх буудал			
	203 буудал	204, 205 буудал	206 буудал

Метроны буудлын уртыг хэтдээ нэг цуваанд 4 хөдлөх бүрэлдэхүүн байхаар тооцож 75 м-ийн урттайгаар төлөвлөсөн.

#### 4.7.3 Метроны шугам тус бүрийн буудлын хүлээн авах, явуулах замын зураг



\*LRT-1-ийн аялал хоорондын хугацаа 6.66 минут ба LRT-2-ийн аялал хоорондын хугацаа 10.00 минут нь 1 цувааны хөдлөх бүрэлдэхүүний жолоодлогын хугацаа шалгах программ (TPS)-аар тооцоолон бодсон ба аялал хоорондын хугацаа нь хөдлөх бүрэлдэхүүн болон хөдлөх бүрэлдэхүүний хоорондох хугацааг харуулдаг.

## 4.8 Галт тэрэгний хөдөлгөөний судалгаа


### 4.8.1 Танилцуулга

Улаанбаатар хотын зорчигч тээврийн хэрэгцээг метроны шугамын багтаамжтай харьцуулан судалж, галт тэрэгний тээвэрлэлтийн багтаамжийг сайжруулах, хурдыг нэмэх зэргээр аялалын хугацааг багасгах, эрчим хүчний зардлыг хэмнэх зэрэг хүчин зүйлүүдийг тооцон үзэх нь бага багтаамжийн төмөр замт тээврийн барилгын ажлыг тохиромжтой аргаар гүйцэтгэх, зорчигч тээврийн хөдөлгөөнийг зүй зохистой төлөвлөхөд чухал ач холбогдолтой болно.

### 4.8.2 Галт тэрэгний жолоодлогын хугацааг тооцох

- Жолоодлогын хугацааны дагуу хувилбар тус бүр дээр метроны шугамын дэвсгэр, дагуу төлөвлөлтийн нөхцөл байдалд тохирсон эрчим хүчийг үр ашигтайгаар ашиглах болон хүрээлэн буй орчны судалгааг үндэслэн хийлээ.
- Хэвтээ тэнхлэгийн шугамд 4 хөдөлх бүрэлдэхүүнтэй 1 цувааг 6 минутын зайдтайгаар, босоо тэнхлэгийн шугамд 2 хөдлөх бүрэлдэхүүнтэй 1 цувааг 10 минутын зайдтайгаар хөдөлгөөнд оруулахаар төлөвлөн судаллаа.

[хүснэгт 4.8.1] Галт тэрэгний жолоодлогын хугацааны зураг



#### (1) Судалгааны дүн

- Галт тэрэгний хөдөлгөөн хийх хугацааг метроны 2 буудлын хоорондох хөдөлгөөнөөр тооцсон бөгөөд хэвтээ, босоо тэнхлэгийн трассыг сонгон хурдны хязгаар, туулах зам, эргэлтийн дэвсгэр, дагуу зураг, метроны буудлын тоо зэрэг нөхцлийг судаллаа.
- Галт тэрэгний жолоодлогын хугацааг тооцоолон боддог (TPS) програмын тооцоолсоноор шаардлагатай эрчим хүч нь хэвтээ тэнхлэгт 264.17кВт, босоо тэнхлэгийн метроны шугамд шаардлагатай эрчим хүч нь 127.48кВт гэж тогтоогдсон.

Метроны үйл ажиллагаанд шаардагдах эрчим хүчийг Part2 4-р бүлэг хотын тээврийн төрлийн техникийн судалгаа, 4.16 цахилгаан, 4.16.6-аас харж болно.

#### 4.8.3 Аялалд зарцуулах хугацаа, аялалын давтамж, нэг цуваанд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүнийг тоог тооцох

##### (1) Ашигласан стандарт норм

Шугам	Хэвтээ тэнхлэг	Босоо тэнхлэг
Судалгаанд хамрагдах хугацаа	2047	2047
Хамгийн их ачаалалтай хэсгийн тээвэрлэлтийн эрэлт, хэрэгцээ(pphpd(passanger per hour per direction), хүн)	4,135	1,236
Шугамын урт (км)	27.66	18.99
Нормт хурд(км/цаг)	34.94	41.85
Галт тэрэг хоорондын хугацаа(минут)	3.0	3.0
Нөөцлөх хувь(%)	12.0	12.0

##### (2) Бүтэн аялалд /2талдаа/ зарцуулах хугацааны тооцоо

$$\text{Бүтэн аялал хийх хугацаа} = \frac{\text{Трассын урт } x 2 x 60}{\text{хурд}} + \text{рейс хоорондын хугацаа}$$

##### (3) Цуваанд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний тоог тооцох томъёо

- Нэг цуваандах хүний тоо = вагоны багтаамж(ачаалалтай цагаар) x 1 цуваан дах x/b тоо
- Нэг цагт шаардлагатай цувааны

$$\text{Хамгийн их ачаалалтай цагийн тээврийн эрэлт, хэрэгцээ} \left( \frac{\text{зорчигч}}{\text{цаг}} x \text{ чиглэл} \right)$$

$$\text{тоо=} \frac{\text{нэг цуваандах хийн тоо}}{60 \text{ минут}}$$

$$\text{Аялал хоорондын хугацаа(мин)}= \frac{\text{цагт шаардлагатай цувааны тоо}}{\text{Бутэн рейс хийх хугацаа}}$$

$$\text{x/b хэрэгцээт тоо (цуваа)}= \frac{\text{Ачаалалтай уеийн рейс хийх хугацаа}}{\text{Ачаалалтай уеийн рейс хийх хугацаа}}$$

$$\text{Нөөц x/b хэрэгцээт тоо(цуваа)}= \text{x/b хэрэгцээт тоо x нөөцлөх хувь (12%)}$$

##### (4) Цуваанд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний тоон үзүүлэлт

Шугам	Хэвтээ тэнхлэг	Босоо тэнхлэг
Цувааны норм	4 x/b 1цуваа	2x/b 1цуваа
Ачааллын хувь(%)	120	120
Цуваан дахь зорчигчдын тоо (хүн)	469	234
1 цагт шаардлагатай вагоны тоо(цуваа)	9	6
аялалын давтамж (минут)	6.66	10
Хөдлөх бүрэлдэхүүний хэрэгцээт тоо(цуваа)	16	6
Нөөц хөдлөх бүрэлдэхүүний хэрэгцээт тоо(цуваа)	2	1
Хэрэгцээт цувааны тоо (цуваа)	18	7
Хэрэгцээт хөдлөх бүрэлдэхүүний тоо(вагон)	72	14

#### 4.8.4 Метроны трассын хүчин чадлын тооцоо

##### (1) Галт тэрэгний хөдөлгөөний төлөвлөлт

- Тээврийн эрэлт хэрэгцээг харгалзан үзэж зорчигчдын тав тухтай байдлыг сайжруулах, нийгмийн шаардлагын дагуу нийслэлийн иргэдийн зорчих хөдөлгөөн идэвхжэдэг цаг ба ба галт тэрэгний үйл ажиллагааг үр ашигтай байлгах гэх мэт төрөл бүрийн нөхцөл байдлыг харгалзаж ачаалалтай үед 4 цаг, энгийн үед 15.5 цаг гэсэн стандартын дагуу 1 өдөрт хийх аялалын тоог дараах байдлаар тооцлов.

[хүснэгт 4.8.2] Галт тэрэгний хөдөлгөөний төлөвлөлт

Метроны шугам	Огноо	Цувааны тоо	Ачаалалтай үеийн		Энгийн үе		1 өдөрт 1 талдаа Галт тэрэгний үйл ажиллагааны давтамж	1 өдөр Галт тэрэгний үйл ажиллагааны давтамж
			цаг/ давтамж	нийт	цаг/ давтамж	нийт		
Хэвтээ тэнхлэг	2047	4 вагон	6.67мин /9 удаа/	46удаа	10мин /6 удаа/	93 удаа	129 удаа	258удаа
Босоо тэнхлэг	2047	2 вагон	10мин /6 удаа/	20удаа	24мин /3 удаа/	47 удаа	71 удаа	142удаа

##### (2) Метроны трассын хүчин чадлын тооцоо

- Метроны трассын хүчин чадал нь 1 өдөрт аялал хийх вагоны тоогоор илэрхийлэгдэх ба вагоны рейс хоорондын хугацааг 3 минутаар зохицуулбал метроны шугамын хүчин чадал нь дор дурьдсантай ижил байна.

$$N = \frac{\bullet}{t} \frac{T \times f}{3.0} = 24 \times 60 \times 0.6 = 288 \text{ удаа}$$

- N = метроны шугамын хүчин чадал T = 1 өдөр( 24 x 60=1440минут),
- f = метроны шугамыг ашиглах хувь, t = метроны буудал хооронд явах хугацаа(минут)

##### (3) Судалгааны үр дүн


- 2047 он хүртэл метроны хөдөлгөөн зохицуулалтын төлөвлөгөөнд ачаалал ихтэй цаг ба ердийн ачаалалтай цаг, рейсийн тоог тооцоолсон бөгөөд хэвтээ тэнхлэгт өдөр 1 талдаа буюу хагас рейсийн тоо нь 129, 2 талдаа буюу бүтэн рейсийн тоо 258, босоо тэнхлэгт хагас рейсийн тоо 71, бүтэн рейсийн тоо 142 байх боломжтой тооцоо гарсан.
- Метроны шугамын хүчин чадал нь анализийн үр дүнд хоногт 288 цуваа нэвтрүүлийн хэмээн тооцогдсон.
- 2047 оны метроны тээврийн үйлчилгээний төлөвлөгөөнд хэвтээ тэнхлэгийн шугам нь өдөрт 258 рейс, босоо шугам нь өдөрт 142 рейс хийнэ гэж тусгагдаж байгаа бөгөөд шугамын хүчин чадал нь 576 рейс байгаа тул шугамын нөөц хүчин чадал нь хэвтээ тэнхлэгт 318 рейс, босоо тэнхлэгт 434 рейс байна гэсэн тооцоо гарсан нь ирээдүйд тээврийн эрэлт хэрэгцээ нэмэгдсэн ч өргөтгөх боломжтой гэж дүгнэж байна.

## 4.9 Метроны вагон депо

### 4.9.1 Товч агуулга

- Депоны байршил нь шугамын төгсгөлд болон шугамын дунд хэсэгт байрладаг боловч хотын метроны депоны байршил ихэвчлэн хотын захад байрлах нь элбэг байдаг.
- Хэвтээ болон босоо тэнхлэгийн шугамын метроны депог тус бүр нэг нэг байхаар төлөвлөсөн бөгөөд метроны 1-р шугамын /хэвтээ тэнхлэг/ депод хүнд засвар үйлчилгээний газар, 2-р шугамын депод хөнгөн засварын газрыг төлөвлөсөн.

[зураг 4.9.1] Депогийн загвар зураг



### 4.9.2 Депоны байршил сонгоход үндэслэл болох нөхцөлүүд

- Төлөвлөсөн шугам дэвсгэр болон дагуу төлөвлөлтийн нөхцөл байдал харилцан зохицсон гол шугамын орох болон гарах шугамын төлөвлөлтөд хүндрэлгүй байх
- Тэгш гадаргуутай, өргөн, чөлөөтэй байх
- Өргөтгөл хийх боломжтой байх
- Шугамын далангийн газар шорооны ажлын ухмалын шороог депогийн газар шорооны ажилд ашиглах боломжтой байх
- Депод ажиллах ажилтнууд ажилдаа ирэх болон тараадад төвөггүй байх.

### 4.9.3 Хүлээж авах болон буцаах шугамын төлөвлөлтийн үндсэн чиг хандлага болон стандарт

- Депогийн үйл ажиллагааны цар хүрээг бүрэн ашиглах боломжийг юуны түрүүнд хангасан байх ёстой:
- Барилга байгууламжын байршилтай зохицсон газар ашиглалтын төлөвлөлтийг дээд зэргээр хангасан эдийн засгийн үр ашигтай хүлээж авах болон буцаах шугам байх
- Гол шугамын нэвтрэх чадварыг хангасан гол шугам болон депог холбосон шугамыг төлөвлөх
- Депог болж өгвөл уртааш хэвээ шугамын дагуу төлөвлөнө.
- Хэвтээ муруйн радиусыг 100 м-с дээш төлөвлөнө.
- Зам төмөр хоорондын зайд нь зам төмрийн голчоос 4м —ээс дээш байхаар төлөвлөх боловч засвар үйлчилгээний тоног төхөөрөмжийн хэмжээ ажиллах орон зайд зэргийг үндэслэн зам төмөр хоорондын зайд төлөвлөнө.


#### 4.9.4 Метроны 1-р шугамын депо

##### (1) Вагон депо байрлах газрын судалгаа


Ангилал	1-р шугам Хувилбар -1	1-р шугам Хувилбар-2
Дэвсгэр зураг		
Байршил	Шугамын эхлэл хэсэгт 103, 104-р буудлын хооронд	Шугамын төгсгөл хэсэгт
Талбайн хэмжээ	150,121 m <sup>2</sup>	220,000 m <sup>2</sup>
Судалгааны дүн	Хувилбар -2 цэвэр усны эх үүсвэртэй ойролцоо байгаа тул депог байрлуулах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан бөгөөд Хувилбар -1 ийг сонгох илүү тохиромжтой гэсэн дүгнэлт гарсан.	

##### (2) Депогийн байршилзүйн судалгаа

[зураг 4.9.2] 1-р шугамын депогийн байрлал



[зураг 4.9.3] 1-р шугамын депогийн дэвсгэр зураг



## [хүснэгт 4.9.1] 1-р шугамын депогийн байршил

Ангилал	Тайлбар	Бусад	
Байршил	Шугамын эхлэл хэсэг 103, 104-р буудлын хооронд байхаар төлөвлөсөн.		
Талбай	150,121 м <sup>2</sup>		
Гол барилга байгууламж	Байгууламжийн хүчин чадал	Төв удирдлагын байр, ажилчдын байр, засвар үйлчилгээний газар, хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлгэн өгөх байр, хөдлөх бүрэлдэхүүнийг хадгалах газар, хөнгөн засвар үйлчилгээ хийх зогсоол, орох болон гарахад техникийн хяналтийн газар, автомат угаалгын газар, харуулын алба, дэд станц, цэвэр, бохир усны техникийн узель, дахин боловсруулах газар, биеийн тамирын талбай, сагс, гар бөмбөг, теннисний талбай гэх мэт.	
	Зам төмрийн байгууламж	Зогсоол, үзлэгийн, туршилт хяналтын, орох гарах, хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлгэн өгөх шугам, техникийн үзлэг хяналтын зам төмөр	
Зогсоолын талбайн хэмжээ	18 цуваа (72хөдлөх бүрэлдэхүүн)	4 х/б 1цуваа болно.	
Амралт чөлөөт цагийн болон ногоон байгууламж	9,210 м <sup>2</sup>		
Авто машины зогсоол	242		

## (3) Депогийн зогсоолын хэмжээг тооцоолох

·Метроны 1-р шугамын тээврийн хэрэгсэлийн эрэлтийн судалгаан “ХЭСЭГ 3 Онолын судалгаа ( 4-р бүлэг тээврийн хэрэгсэлийн эрэлт хэрэгцээний хэтийн төлөв, 4.5 хэтийн төлөвийн судалгааны дүгнэлт, 4.5.2 метроны буудал тус бүрийн эрэлт хэрэгцээний тооцоо судалгаа)”-ны дүнд гарсан оргил цагийн зорчигчийн судалгаа болон “ХЭСЭГ2, Техникийн судалгаа (4-р бүлэг Үндсэн тээврийн хэрэгслийн судалгаа, 4.8 Хөдөлгөөний үйл ажиллагааны судалгаа” –ны дүгнэлтэнд тулгуурлан депогийн зогсоолын хэмжээг тооцоолон гаргасан.

## [хүснэгт 4.9.2] Депогийн зогсоолын хэмжээг тооцоолох

Ангилал	Нийт шаардагдах цувааны тоо	Нөөц цувааны тоо	Нийт
Цуваа (4х/б 1цуваа)	16	2	18

## (4) Шаардагдах шугам

Ангилал	Шаардагдах шугамын тоо	Хүчин чадал	Тайлбар
Хүнд засварын төвийн шугам	1	Хүнд оврын механизм, төхөөрөмжийн засвар	
Техникийн үзлэг хяналт	Өдөр тутмын үзлэг	1	Үзлэг, засварын
	Сар бүрийн үзлэг	1	Үзлэг, засварын
	Автомат үзлэг	1	Үзлэгийн

Ангилал	Шаардагдах шугамын тоо	Хүчин чадал	Тайлбар
Зогсоол	6	Хөдлөх бүрэлдэхүүний зогсоол,	
Засвар үйлчилгээний шугам	1		
Хөдлөх бүрэлдэхүүний доод хэсгийн засварын шугам	1	Дугуй	
Их цэвэрлэгээний зориулалтын шугам	1	Хөдлөх бүрэлдэхүүний цэвэрлэгээ	
Үргал цэвэрлэгээний шугам	2	Хөдлөх бүрэлдэхүүний цэвэрлэгээ	
Автомат угаалгын шугам	1	Хөдлөх бүрэлдэхүүний цэвэрлэгээ	
Агуулахын шугам	1	Хөдлөх бүрэлдэхүүний доод хэсгийн цэвэрлэгээ	
Туршилтын жолоодлогын шугам	1	Туршилтын жолоодлого, үзлэгийн	
Орж гарах шугам	2	Хөдлөх бүрэлдэхүүний орж гарах	
Нийт	20		

## (5) Салаалагч

Ангилал		Нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
Салаалагч	F6	Иж бүрдэл	17	
	F10	Иж бүрдэл	6	

## (6) Депо руу орох шугам

Депогийн байршилаас шалтгаалан үндсэн гол шугам болон депоруу орох шугамыг төлөвлөдөг бөгөөд 103 болон 104 –р буудлын хооронд гол шугамаас салаалан депо руу орох шугамыг төлөвлөсөн.

[хүснэгт 4.9.3] 1-р шугамын депо руу орох шугамын техникийн нөхцөл

Ангилал	Урт (м)	Хэвтээ налуугийн радиус(м)	Дагуу налуу(%)	Тайлбар
Орох шугам -1	Газар шорооны ажил	667	330	35
	Гүүр	197		
	Нийт	864		
Орох шугам -2	Газар шорооны ажил	643	270	35
	Гүүр	227		
	Нийт	870		

## (7) Депо доторх авто зам болон нэвтрэн орох авто замын төлөвлөлт


Ангилал	Депо доторх авто зам	Депо руу нэвтрэх авто зам	Тайлбар
Хучилт	Асфальт	Асфальт	
Өргөн (м)	5.5~7.0	7.5	Явган хүний замгүй
Хязгаарлагдах хурд(км/цаг)	40	40	
Урт (м)	1,735	896	

## 4.9.5 Метроны 2-р шугамын депо


## (1) Депоны байрлах газрын судалгаа

Ангилал	2-р шугам Хувилбар -1	2-р шугам Хувилбар-2
Дэвсгэр зураг		
Байршил	Чингис хаан онгоцны буудлын ойролцоо газар	Шугамын эхлэлийн хэсэг 201, 202-р буудлын хооронд
Талбайн хэмжээ	72,482 м <sup>2</sup>	46,265 м <sup>2</sup>
Судалгааны дүн	Хувилбар -2 хотын шинэ суурьшлын бүсийн төлөвлөлтөд орсон газар учраас тохиромгүй. Хувилбар -1 онгоцны буудлыг хөндлөн гарч байгаа боловч газар тэгшлэх ухмалын ажил шаардлагагүй, мөн онгоцны хөөрч буурах хамгаалалтын бүс зэрэг байдгийг харгалзан үзэж сонгосон болно.	

## (2) Депогийн байршил зүйн судалгаа



[зураг 4.9.4] 2-р шугамын депогийн байрлал



[зураг 4.9.5] 2-р шугамын депогийн дэвсгэр зураг

[хүснэгт 4.9.4] 2-р шугамын депогийн байршил

Ангилал	Тайлбар	Бусад	
Байршил	Чингис хаан онгоцны буудлын ойролцоо		
Талбай	72,482 м <sup>2</sup>		
Гол барилга байгууламж	Гол барилга байгууламж	Төв удирдлагын байр, ажилчдын байр, засвар үйлчилгээний газар, хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлгэн өгөх байр, хөдлөх бүрэлдэхүүнийг хадгалах газар, хөнгөн засвар үйлчилгээ хийх зогсоол, орох болон гарахад техникийн хяналтийн газар, автомат угаалгын газар, харуулын алба, дэд станц, цэвэр, бохир усны техникийн узель, дахин боловсруулах газар, биений тамирын талбай, сагс, гар бөмбөг, теннисний талбай гэх мэт.	
	Зам төмрийн байгууламж	Зогсоол, үзлэгийн, туршилт хяналтын, орох гарах, хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлгэн өгөх шугам, техникийн үзлэг хяналтын зам төмөр	
Зогсоолын талбайн хэмжээ	7 цуваа /14 хөдлөх бүрэлдэхүүн/	2 х/б 1 цуваа болно	
Амралт чөлөөт цагийн болон ногоон байгууламж	5,267 м <sup>2</sup>		
Авто машины зогсоол	110		

## (3) Депогийн зогсоолын хэмжээг тооцоолох

- Метроны 1-р шугамын тээврийн хэрэгсэлийн эрэлтийн судалгаан “ХЭСЭГ 3 Онолын судалгаа ( 4-р бүлэг тээврийн хэрэгсэлийн эрэлт хэрэгцээний хэтийн төлөв, 4.5 хэтийн төлөвийн судалгааны дүгнэлт, 4.5.2 метроны буудал тус бүрийн эрэлт хэрэгцээний тооцоо судалгаа)”-ны дунд гарсан оргил цагийн зорчигчын судалгаа болон “ХЭСЭГ2, Техникийн судалгаа (4-р бүлэг Үндсэн тээврийн хэрэгсэлийн судалгаа, 4.8 Хөдөлгөөний үйл ажиллагааны судалгаа” –ны дүгнэлтэнд тулгуурлан депогийн зогсоолын хэмжээг тооцоолон гаргасан.

[хүснэгт 4.9.5] Депогийн зогсоолын хэмжээг тооцоолох

Ангилал	Нийт шаардагдах цувааны тоо	Нөөц цувааны тоо	Нийт
Цуваа (2х/б 1цуваа)	6	1	7

## (4) Шаардагдах шугам

Ангилал		Шаардагдах шугамын тоо	Хүчин чадал	Тайлбар
Техникийн үзлэг хяналт	Өдөр тутмын үзлэг	1	Үзлэг, засварын	
	Сар бүрийн үзлэг	1	Үзлэг, засварын	
Зогсоол		2	Хөдлөх бүрэлдэхүүний зогсоол,	
Засвар үйлчилгээний шугам		1		
Их цэвэрлэгээний зориулалтын шугам		1	Хөдлөх бүрэлдэхүүний цэвэрлэгээ	
Ургал цэвэрлэгээний шугам		1	Хөдлөх бүрэлдэхүүний цэвэрлэгээ	
Автомат угаалгын шугам		1	Хөдлөх бүрэлдэхүүний цэвэрлэгээ	
Агуулахын шугам		1	Хөдлөх бүрэлдэхүүний доод хэсгийн цэвэрлэгээ	
Туршилтын жолоодлогын шугам		1	Туршилтын жолоодлого, үзлэгийн	
Орж гарах шугам		2	Хөдлөх бүрэлдэхүүний орж гарах	
Нийт		12		

## (5) Салаалагч

Ангилал		Нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
Салаалагч	F6	Иж бүрдэл	9	
	F10	Иж бүрдэл	6	

## (6) Депо руу орох шугам

Депогийн байршилаас шалтгаалан үндсэн гол шугам болон депоруу орох шугамыг төлөвлөдөг бөгөөд 2-р шугамын эхлэл хэсгийн гол шугамаас салаалан депо руу орох шугамыг төлөвлөсөн.

[хүснэгт 4.9.6] 2-р шугамын депо руу орох шугамын техникийн нөхцөл

Ангилал		Үрт (м)	Хэвтээ налуугийн радиус(м)	Дагуу налуу(%)	Тайлбар
Орох шугам -1	Газар шорооны ажил	746	1700, 1700, 900	level	
Орох шугам -2	Газар шорооны ажил	77	180, 230, 900	35, 35	
	Газар доорх хайрцган бүтээц	235			
	Аркан хэлбэрийн бүтээц	447			
	Нийт	759			

(7) Депо доторх авто зам болон нэвтрэн орох авто замын төлөвлөлт

Ангилал	Депо доторх авто зам	Депо руу нэвтрэх авто зам	Тайлбар
Хучилт	Асфальт	Асфальт	
Өргөн (м)	6.0~7.0	7.5	Явган хүний замгүй
Хязгаарлагдах хурд(км/цаг)	40	40	
Үрт (м)	1,294	1,863	

## 4.10 Газар шорооны ажил барилга байгууламжийн төлөвлөлт

### 4.10.1 Газар шорооны ажлын төлөвлөлт

(1) Газар шорооны ажлын үүрэг роль

- Галт тэрэгний аюулгүй хөдөлгөөнийг хангахын тулд далангийн байгууламж нь зам төмөр хөдөлгөөнгүй сайн бэхлэгдэж байх шаардлагатай.
- Доод далангийн байгууламж зөөлрөн нурахаас хамгаалагдсан байна.
- Шороон далан нь галт тэрэгнээс ирэх ачааллыг доод далангийн байгууламж руу жигд хуваарилах ёстой.
- Шороон даланг налуу хийснээр борооны ус тогтохоос хамгаална.

(2) Газар шорооны ажлын ангилал

- Газар шорооны ажил нь газар ухах, шороо овоолох гэсэн үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд шороо овоолох ажил нь дээд ба доод шороон далангийн ажлаас бүрдэнэ.
- Дээд шороон далан гэдэг нь барилгын ажлын гадаргуунаас доош 1.5м гүнд байх шороон овоолгын хэсгийг хэлнэ. Доод далан гэдэг нь дээд далангийн доод хэсгээс газрын гадарга хүртлэх овоолсон шороог хэлнэ.


(3) Газар шорооны ажлын төлөвлөлтийн дүн

- Ашиглалт, засвар үйлчилгээ зэргийг харгалзан далангийн өргөн нь 11.9м байхаар төлөвлөв.
- Геологийн онцлог ба налуу замд тохиорх налуу болон налуу гадаргууг хамгаалах аргыг сонгоно.
- Далангийн налуу урт байх тохиолдолд дунд нь шатлал хийнэ.
- Борооны ус зайлцуулах байгууламж болон ус тогтохоос сэргийлэн тохиромжтой хэмжээгээр налуу гадаргуутайгаар төлөвлөнө.
- Зам төмрийн доорх даланг зам төмрийн гол тэнхлэгээс 2 тийш 3% -ийн хөндлөн налуутайгаар суурилуулан далангийн гадаргууд ус тогтоооргүйгээр төлөвлөсөн.

(4) Газар шорооны ажлын налууг төлөвлөх (Далан)

- Ухмалаас гарсан шороог зам төмрийн даланд ашиглах ба зохих стандартын дагуу далангийн налууг төлөвлөсөн.
- Шороон далангийн налуу болон хөрсний байдал зэргээс хамааран зам төмрийн далангийн хажуугийн налууг огцом бус алгуураар хийж болох ба далангийн дээд гадаргуунаас доош 5м тутамд шатлал(өргөн нь 1.5м) хийх ба ус тогтоохгүйн тулд 5% -ийн налуутайгаар хийнэ. Шаардлагатай бол налуу гадаргууг хамгаалалтыг хийнэ.

[зураг 4.10.1] Далангийн стандарт огтлолын зураг



#### 4.10.2 Бүтээцийн газар шорооны ажлын төлөвлөлт

##### (1) Газар шорооны ажлын төлөвлөлт

###### 1) Тулц хана

- Тулц ханыг ил гүүрэн хэлбэрээр хотыг нэвтрэн өнгөрч байгаа хэсэгт төлөвлөж байгаа бөгөөд хэсэг бүхий газарт дуу чимээ багасгах давхар зориулалтаар төлөвлөж байна.

[хүснэгт 4.10.1] метроны 1-р шугамын хамгаалалтын тулц хана төлөвлөх хэсгүүд

Ангилал	Төлөвлөгдөх газар	Шугамын аль талд байрлах	Тулц ханын өндөр(м)	Үргт (м)	Тайлбар
1	24км600~24км804	Зүүн, баруун талд	3.0	408	Дуу чимээ тусгаарлах хананы суурь
2	27км496~27км965	Баруун	3.0	469	Дуу чимээ тусгаарлах хананы суурь
3	27км496~27км965	Зүүн	4.0~8.0	469	
4	28км075~28км380	Баруун	3.0	305	Дуу чимээ тусгаарлах хананы суурь
5	28км075~28км180	Зүүн	4.5	105	
6	28км180~28км380	Зүүн	3.0	200	Дуу чимээ тусгаарлах хананы суурь

## 2) Дуу чимээ тусгаарлагч хана

Метроны ил шугамын дагуух байрлаж буй хэсэг иргэдийн амгалан байдлыг алдагдуулахгүйн тулд дуу чимээ тусгаарлах ханыг төлөвлөсөн.

[хүснэгт 4.10.2] метроны 1-р шугамын дуу чимээ тусгаарлах хана төлөвлөх хэсгүүд

Ангилал	Төлөвлөгдөх газар	Шугамын аль талд байрлах	Ханын өндөр(м)	Үрт (м)	Тайлбар
1	0км840~1км705	Зүүн	4.0	865	ГҮҮР
2	0км840~1км705	Баруун	4.0	865	ГҮҮР
3	1км815~2км520	Зүүн	4.0	705	ГҮҮР
4	1км815~2км520	Баруун	4.0	705	ГҮҮР
5	5км460~5км980	Зүүн	4.0	520	ГҮҮР
6	5км460~5км980	Баруун	4.0	520	ГҮҮР
7	6км440~7км775	Зүүн	4.0	1,335	ГҮҮР
8	6км440~7км775	баруун	4.0	1,335	ГҮҮР
9	7км885~8км995	Зүүн	4.0	1,110	ГҮҮР
10	7км885~8км995	баруун	4.0	1,110	ГҮҮР
11	9км105~12км020	Зүүн	4.0	2,915	ГҮҮР
12	9км105~12км020	баруун	4.0	2,915	ГҮҮР
13	24км600~25км165	Зүүн	4.0	565	Барилгын ажил
14	24км600~25км165	баруун	4.0	565	Барилгын ажил
15	25км275~26км245	Зүүн	4.0	970	ГҮҮР
16	25км275~26км245	баруун	4.0	970	ГҮҮР
17	26км355~27км965	Зүүн	4.0	1,610	ГҮҮР
18	26км355~27км965	баруун	4.0	1,610	ГҮҮР
19	28км075~28км380	Зүүн	4.0	305	Барилгын ажил
20	28км075~28км380	баруун	4.0	3,780	Барилгын ажил

[хүснэгт 4.10.3] метроны 2-р шугамын дуу чимээ тусгаарлах хана төлөвлөх хэсгүүд

Ангилал	Төлөвлөгдөх газар	Шугамын аль талд байрлах	Ханын өндөр(м)	Үрт (м)	Тайлбар
1	5км280~5км420	Зүүн	4.0	140	ГҮҮР
2	7км180~7км520	Зүүн	4.0	340	ГҮҮР

**3) Хамгаалалтын хаалт, хашаа**

Метроны шугамын дагуу болон буудлын ойролцоо газруудад хүн эсвэл мал амьтан нэвтрэн орох магадлал ихтэй байдаг тул аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын хаалт хашаа зэргийг төлөвлөх шаардлагатай байdag.

[хүснэгт 4.10.4] метроны 1-р шугамын дагуу хамгаалалтын хаалт хашаа төлөвлөх хэсгүүд

Ангилал	Төлөвлөгдөх газар	Шугамын аль талд байрлах	Хаалтын өндөр(м)	Үрт (м)	Тайлбар
1	11км820~12км015	Зүүн баруун талд	2.3	360	106-р буудал
2	24км595~24км808	Зүүн баруун талд	2.3	580	118-р буудал
3	27км495~27км965	Зүүн баруун талд	2.3	510	120-р буудал
4	28км075~28км380	Зүүн баруун талд	2.3	540	121-р буудал
5	0км250~0км893	Зүүн баруун талд	2.3	2,450	Депо руу нэвтрэх шугам
6	Депо	Зүүн баруун талд	2.3	2,000	Депо

[хүснэгт 4.10.5] метроны 2-р шугамын дагуу хамгаалалтын хаалт хашаа төлөвлөх хэсгүүд

Ангилал	Төлөвлөгдөх газар	Шугамын аль талд байрлах	Хаалтын өндөр(м)	Үрт (м)	Тайлбар
1	0км000~0км444	Зүүн баруун талд	2.3	914	
2	3км311~3км442	Зүүн баруун талд	2.3	370	202-р буудал
3	9км327~10км650	Зүүн баруун талд	2.3	2,750	206-р буудал
4	11км040~11км198	Зүүн баруун талд	2.3	340	206-р буудал
5	0км000~0км738	Баруун	2.3	40	Депо руу нэвтрэх шугам
6	0км000~0км751	Зүүн	2.3	752	Депо руу нэвтрэх шугам
7	Депо	Зүүн баруун талд	2.3	1,392	Депо

**4) Авто зам**

- Метроны барилгын ажлын явцад авто замын хөдөлгөөний зохицуулалтыг хөдөлгөөнд их хэмжээний саад тоттор учруулахгүй байхаар төлөвлөнө.
- Одоо ашиглагдаж буй болон метроны шугамын төлөвлөлтөд авто зам болон уулзварууд давхцах тохиолдолд олон түвшинт уулзвар болон нэг түвшний уулзварыг төлөвлөнө.

**5) Хөлдөлтөөс хамгаалах төлөвлөлт**

- Улаанбаатар хотын өвлийн агаарын хэмийг  $-40^{\circ}$  -д тооцон далангийн аюулгүй байдлыг хангахын үүднээс 3м хүртэлх өндөртэйгээр төлөвлөлтийг хийсэн.

**6) Уулын нуранги, хөрсний гулсалтаас хамгаалах төлөвлөлт**




- Эргэцэг болон уулын налуу хэсгийг хөрсний угаагдал, нуралтаас хамгаалах, салхины өгөршилт зэргийг тооцон төлөвлөлтийг хийнэ.

#### 4.11 Ухмалын бүтээцийн төлөвлөгөө




##### (1) Үндсэн чиглэл болон тооцооны үндсэн нөхцөл

<p><b>Барилгын ажил болон аюулгүй байдал</b></p> <p>Барилгын талбайн нөхцөл, барилгын ажлын үр ашигтай байдлыг харгалзан бүтээцийг төлөвлөхөд нарийвчилсан шинжилгээ, судалгаанд тулгуурласан зураг төслийг үнэн зөв хийх</p> <p><b>Эдийн засгийн үр ашиг болон хүрээлэн буй орчинд ээлтэй байдал</b></p> <p>Хамгийн тохиромжтой байдлыг тооцсон хамгийн оновчтой огтлог</p> <p>Барилгын ажлын үеийн дуу чимээ, чичирхийлийг багасгах</p>		<p><b>Тооцооны гол нөхцөл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Бүтээцийн аюулгүй байдал, хэрэглэх тооцоо, тэсвэрлэлтийн байдал зэргийг сайжруулах төлөвлөгөө</li> <li>Барилгын ажлын үе шат бүрт болон ажил дууссаны дараах бүтээцийн тогтворталтын байдал ба хөвөх чадварын тооцоо</li> <li>Газар хөдлөлтийн тооцоо</li> </ul>
---	--	---

##### (2) Гол шугамын ухмалын бүтээц

Ангилал	U-TYPE	BOX-TYPE	Тунелийн агааржуулалтын хоолой
Огтлог			
Төлөв лөлт	МЕТРОНЫ ШУГАМ -1 : L = 0.460 км МЕТРОНЫ ШУГАМ -2 : L = 0.779 км	МЕТРОНЫ ШУГАМ -1 : L = 10.810 км МЕТРОНЫ ШУГАМ -2 : L = 11.457 км	МЕТРОНЫ ШУГАМ -1 : 11 газар МЕТРОНЫ ШУГАМ -2 : 8 газар

##### (3) Ухмал дахь метроны буудал

Анги лал	Салангид зорчих тавцантай	Салангид зорчих тавцантай+туслах зам	Арал хэлбэрийн зорчих тавцантай
Огт лол			
Төлөв лөлт	МЕТРОНЫ ШУГАМ -1 : 8 газар МЕТРОНЫ ШУГАМ -2 : 6 газар	МЕТРОНЫ ШУГАМ -1 : 1 газар МЕТРОНЫ ШУГАМ -2 : 1 газар	МЕТРОНЫ ШУГАМ -1 : 3 газар МЕТРОНЫ ШУГАМ -2 : 3 газар




## (4) Газар доорх метроны буудал

Ангилал	Метроны буудлын дэвсгэр зураг
Салангид зорчих тавцантай	
Салангид зорчих тавцантай + Туслах шугам	
Аралан зорчих тавцантай	

## (5) Гол тооцооны нөхцөл

Тэсвэрлэлтийн байдал зураг төсөл	Газар хөдлөлтийн зураг төсөл	Цаг хугацааны хамааралтай шинжилгээ
Дотоод үзүүлэлтийн тэнцвэрт байдлыг сайжруулах	Газар хөдлөлтийн чичирхийллийг динамик шинжилгээ	Гулсалт ба хуурдай агшилтын аюулгүй байдал
Барилгын ажлын үе шатын үе хүчдлийн тооцоо	Хөндлөн холбоот моделийн тооцоо	Галд тэсвэртэй байдлын тооцоо
Гидратын дулаан ялгаруулалтын шинжилгээний үндсэн дээр бетон цутгалтын ажлын өндрийг тодорхойлох	Баруун өнцгийн суналтын хүчдэлд тохируулан арматурыг дэвсэх	Галд тэсвэртэй байдлыг хангахуйц гадна бетоны зузааныг төлөвлөх

## (6) Суурийн хэлбэрийг тооцох

Анги лал	Шууд суурь/гадасгүй/	Төмөр гадсан суурь	Барилгын талбай дээр цутгах гадсан суурь
Огтлол			
Онцлог	<ul style="list-style-type: none"> <li>Тулах давхарга нимгэн тохиолдолд төлөвлөдөг</li> <li>Бусад суурьтай харьцуулахад бат бөх сайтай, хэв гажилтын хэмжээ бага</li> <li>Хадан давхарга гүнд байрлах хөрсний усны түвшин өндөр тохиолдолд тохиромжтүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Захад үйлчлэх тулах хүч их байхад тохиромжтой</li> <li>Эвдрэлтээс хамгаалах, жолоодлогын аргачлал хэрэгтэй</li> <li>Ган материалын зэврэлтээс хамгаалах аргачлал хэрэгтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Материалаар хангах боломжтой, үнэ хямд</li> <li>Суурь болон гадасны эгнээгээр бүтээцийн тогтвортжуулалт боломжтой</li> <li>Радиус томтой гадасыг суурилуулах боломжтой</li> </ul>
Тооцоо ны дун	<ul style="list-style-type: none"> <li>Метроны буудал болон гол шугамын хайрцган суурийг хадан хөрс болон өгөршсөн чулуун давхаргад суурилуулдаг.</li> <li>Суурийн тогтвортжуулалтын тооцооны дунд аюулгүй байдал сайтай болон эдийн засгийн хэмнэлттэй байдлыг харгалзан шууд суурийг төлөвлөнө</li> </ul>		
Санал болгох	O		

## (7) Түр байгууламжтай хэсэг

Ангилал	Урт, хэдэн газар	Шороон бүтээц	Ус тусгаарлах арга
МЕТРОНЫ ШУГАМ -1	Метроны буудал	12 газар	H-Pile+Шороон хана+Анкер
	Гол шугамын агааржуулалтын хоолой	11 газар	H-Pile+Шороон хана+Анкер
	Гол шугамын хайрцаг	10.81 км	H-Pile+Шороон хана+Анкер
	Гол шугамын U-Type	0.46 км	H-Pile+Шороон хана
МЕТРОНЫ ШУГАМ -2	Метроны буудал	10 газар	H-Pile+Шороон хана+Анкер
	Гол шугамын агааржуулалтын хоолой	8 газар	H-Pile+Шороон хана+Анкер
	Гол шугамын хайрцаг	11.38 км	H-Pile+Шороон хана+Анкер
	Гол шугамын U-Type	0.49 км	H-Pile+Шороон хана

## (8) Түр байгууламжийн төлөвлөгөө

Ангилал	Хөрсөн битүүлэх хананы арга	Шороон хананы дам нурууны арга		Анги лал	Ухмалын бэхэлгээний ажлын төлөвлөлт
	H-Pile+Хөрсөн хавтан	Тулах дам нуруу	Хөрсөн анкер		
Огтлол				Огтлол	
Онцлог	<ul style="list-style-type: none"> <li>Богино хугацаанд барих боломжтой</li> <li>Зөөлөн тул тогтвортойлтуулж ирэхийн мөнгөн тусгай арга шаардлагатай</li> <li>Ус тасгаарлах тусгай арга шаардлагатай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хатуулаг сайтай, бэхэлгээ хийх шаардлагатай</li> <li>Барилгын ажлын хялбар, өргөн хэрэглэгддэг</li> <li>Тулах дам нуруутай тул барилгын ажил хийх орон зай багасна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажил хийхэд чөлөөтэй орон зай хэрэгтэй</li> <li>Хөрс чийг авахад бүтээц хэврэгшинэ</li> <li>Ойролцоо газрыг ашигладаг тул иргэдийн гомдол гарч болзошгүй</li> </ul>	Дүгнэлт	<ul style="list-style-type: none"> <li>Замын хөдөлгөөн зохицуулах болон ухмалын бэхэлгээний тогтвортойлтыг сайжруулж болохуу цаар бэхэлгээний ажлын төлөвлөгөөг ёшат бүрээр боловсруулах</li> </ul>
Дүгнэлт	Барилгын талбайн нөхцөл байдлыг (Эргэн тойрны байшин барилга болон хөрсний онцлог) харгалзан хөрсөн бэхэлгээний хана болон ус тасгаарлах аргыг хэрэглэж болно.				

## (9) Түр байгууламжийн төлөвлөлтийн байдал

Анги лал	U-TYPE	BOX-TYPE	Агааржуулах суваг	Метроны буудал
Огтлол				
Хэрэглэх	<p>Шороон бэхэлгээний хананы арга : H-Pile+Хөрсөн хавтан +(Grouting C.T.C 800)</p> <p>Тулгуурын хэлбэр : Strut+Earth Анкер</p>			


## (10) Түр байгууламжийн тогтвортойллын судалгааны дүн

Анги лал	Horizontal Displacement	Stress Distribution	Beam on Elasto-plastic Foundation Model Method	3D Modeling Analysis
Огтлол				
Дүгнэлт	Хазайлтын момент, хөндлөн хүч, хэв гажилт, тулах дам нуруун тэнхлэгийн хүч зэрэг зөвшөөрөгдөх стандартын дагуу тогтвортойлтын байдлыг сайжруулах			



## (11) Гол тооцоонууд

Ангилал	Тооцооны нэр төрөл
Байшин барилга	·Байшингийн налууг хэмжих, ан цавыг хэмжих
Метроны буудлын бүтээц	·Арматурын хүчдлийн тооцох, хөрсний усны түвшин тогтоох, хөрсний суултыг тооцох, хөрсний гадаргууны суултын тооцо
Метроны зам төмрийн хэсэг	·Ачаалал тооцох(Strut, E/A), хэв гажилтын хувийг тооцох, (Strut), хөрсний налууг тооцох, , хөрсний усны түвшин тооцох, хөрсний суултыг тооцох, хөрсний гадаргууны суултын тооцо


## (12) Хөрсний усны түвшингийн нөлөөллийг тооцох төлөвлөгөө

Ангилал	Агуулга		
Дагуу огтлол			
Ангилал	Газар	Үрт	Ашиглах хэсэг
МЕТРОНЫ ШУГАМ-1	1 газар	L=12.12 км	STA. 12 км 185 ~ 24 км 305
МЕТРОНЫ ШУГАМ-2	2 газар	L=2.52 км	STA. 0 км 618 ~ 3 км 138
		L=9.69 км	STA. 11 км 340 ~ 21 км 030
Дүгнэлт	Ухмалын хэсэгт хөрсний усны нөлөөллийг судласны дунд хөрсний даралтад тэсвэрлэх чадварыг дээшлүүлэхийн тулд хөвөлтийн хүчинээс хамгаалах анкер бэхэлгээг хэрэглэхгүй		

## (13) Газар шорооны ажлын хэсгээс шууд гүүрийн бүтээцэд шилжих байдал

Ангилал	Агуулга		
Дагуу огтлол			
Дэвсгэр зураг			
Ангилал	Хэдэн газар	Урт	Байрлал
МЕТРОНЫ ШУГАМ -1	2 газар	L=365 м	STA. 11 км 820 ~ 12 км 185
МЕТРОНЫ ШУГАМ -1	2 газар	L=500 м	STA. 24 км 305 ~ 24 км 805
МЕТРОНЫ ШУГАМ -2	3 газар	L=174 м	STA. 0 км 444 ~ 0 км 618
МЕТРОНЫ ШУГАМ -2	3 газар	L=305 м	STA. 3 км 138 ~ 3 км 443
МЕТРОНЫ ШУГАМ -2	3 газар	L=300 м	STA. 11 км 040 ~ 11 км 340

## (14) Газар шорооны ажлын хэсгээс шууд гүүрийн бүтээцэд шилжих ажлын төлөвлөгөө




Ангилал	Ерөнхий огтлол	Агуулга
Огтлол		
Дүгнэлт	<ul style="list-style-type: none"> <li>Хотын төвийн хэсэгт газар эзлэх талбайг багасгах <math>\Rightarrow</math> U-TYPE бүтээцийг сонгох</li> <li>Засвар үйлчилгээний үед аюулгүй байдлыг хангасан бүтээц төлөвлөх боломжтой</li> </ul>	

## 4.12 Гүүрэн байгууламжийн төлөвлөлт

### (1) Үндсэн чиг хандлага ба гол тооцоо хийх нөхцөл

Үйл ажиллагаа ба аюулгүй байдал		Харгалзан үзэх зүйлс
<p>• Аюулгүй байдал, тэсвэрлэлт, зашиглалт, эдийн засгийн хэмнэлт, барилгын ажлын байдал, үйл ажиллагаа</p> <p>Хүрээлэн буй орчинд ээлтэй гүүрийн зураг төсөл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хотын төв хүрээлэн буй орчинг судлах</li> <li>• Хотын төвд дуу чимээ, доргилт багасгах,</li> <li>• Хүрээлэн буй орчныг хамгаалах</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>• Хүрээлэн буй орчинд ээлтэй, хотын өнгө үзэмжинд харшлах эсэхийг харгалзах</li> <li>• Замын уулзвар зэрэг бүтээцтэй хэсгийн алгасал, болон доогуур нэвтрэн өнгөрөх боломжийг тооцох</li> <li>• Улаанбаатар хотын уур амьсгал(хамгийн хүйтэн-40°C)-д барилгын ажлыг гүйцэтгэж болох эсэх ба ашиглаж болох эсэхийг харгалзах</li> </ul>

### (2) Гүүрийн дээд бүтээц буюу явах ангийн тооцоо

Анги лал	P.S.C U-Girder	P.P.C Girder	P.S.C I-GIRDER
Огт Лол			
Онц лог	<ul style="list-style-type: none"> <li>• Алгасалын урт 25~35 м байх тохиолдолд хэрэглэдэг арга</li> <li>• Үйлдвэрт хийсэн бүтээц ба хэсэгчилсэн угсралттай тул барилгын ажил гүйцэтгэхэд хялбар</li> <li>• Битүү огтлолтой тул хотын өнгө үзэмжинд муугаар нөлөөлнө</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Алгасалын урт 40~60 м байх тохиолдолд хэрэглэдэг</li> <li>• Холбох хэсэг хэврэг, үргэлжилсэн цул байдлаар хийх боломжгүй</li> <li>• Хавтанд эвдрэл гарвал дам нуруунд мөн адил эвдрэл үүснэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Алгасалын урт 40~45 м байх тохиолдолд хэрэглэнэ</li> <li>• Дам нурууг үйлдвэрт бэлтгэсэн ба қран ашиглан барилгын ажлыг хялбарчилдаг</li> <li>• Задгай огтлолтой тул хотын өнгө үзэмжид муугаар нөлөөлөхгүй</li> </ul>
Санал	• Хотын төвийг дайран өнгөрөх тул хотын төвийн өнгө үзэмж, барилгын ажлыг гүйцэтгэх аргыг харгалзан PSC U-Girder дам нуруут бүтээцийг хэрэглэх нь тохиромжтой		
Төлөв лөлт	<p>МЕТРОНЫ ШУГАМ -1 : L = 13.150 км</p> <p>МЕТРОНЫ ШУГАМ -2 : L = 5.445 км</p>	-	-



(3) Урт алгасалтай (Уулзвар ба гол нэвтрэн өнгөрөх) гүүрийн дээд бүтээцийн хийцийн судалгаа

Анги лал	P.S.C BOX Girder	S.T BOX Girder	P.C.T GIRDER
Огт лол			
Онц лог	<ul style="list-style-type: none"> <li>Алгасалын урт 40~60 м байхад хэрэглэдэг</li> <li>Динамик тогтвортойлжилт сайтай</li> <li>Барилгын талбайд цутгадаг тул чанарт доголдол үүсэх магадлалтай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>60 м дээш урттай алгасалын байгууламжтай үед хэрэглэнэ</li> <li>Хүйтний улиралд амархан хагарал үүсдэг, засвар үйлчилгээ хийхэд тохиromжгүй</li> <li>Барилгын ажил хэт өндөр тул эдийн засгийн хувьд үр ашиггүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Алгасалын урт 40~45 м урттай байхад хэрэглэнэ</li> <li>Муруйн хэсгийн цуцалтын хөдөлгөөн боломжгүй</li> <li>Том кран шаардлагатай</li> </ul>
Дүг нэлт	Уулзвар ба голын хэсгийг нэвтрэн өнгөрөх хэсгийн алгасалын урт ба эдийн засгийн үр ашигийг харгалзан P.S.C BOX GIRDER дам нуурт бүтээцийг хэрэглэх нь тохиromжтой.		
Төлөв лөлт	<b>МЕТРОНЫ ШУГАМ -1 :</b> $L = 13.150 \text{ km}$ <b>МЕТРОНЫ ШУГАМ -2 :</b> $L = 5.445 \text{ km}$	-	-




(4) Гүүрийн доод бүтээц буюу тулгуур төлөвлөлт (Захын тулгуур)




Анги лал	Т хэлбэр	Хүндийн жин нь хажуу талдаа хэлбэр	Хайрцааг хэлбэр
Огт лол			
Онц лог	<ul style="list-style-type: none"> <li>Бетон хэмнэх боломжтой</li> <li>Хийц нь энгийн тул барилгын ажил хялбар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Их биеийн огтлол хэсэгт үүсэх суналтын хүчдлийг харьцуулан арматуран бэхэлгээ хийх</li> <li>Доогуурх автозамыг өргөтгөх боломжгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Доогуур өнгөрөх авто зам дээр зэлэх талбай том тул хотын төв хэсэгт төлөвлөхөд зохимжгүй</li> <li>Битүү огтлолтой тул хотын өнгө үзэмжид сөрөгөөр нөлөөлнө</li> </ul>
Санал	Гүүрийн байгууламж төлөвлөгдөх хэсгийн ихэнх нь хотын төвд байгаа тул захын тулгуурын өндөр 7 м орчим байхад зохимжтой бөгөөд тулгуурын суурь жижиг, хүрээлэн байгаа орчинд нөлөөлөх нөлөөлөл багатай тул Т хэлбэрийг сонгох		

## (5) Гүүрийн доод бүтээц буюу тулгуур төлөвлөлт (Завсрыйн тулгуур)




Анги лал	I хэлбэрийн завсрыйн тулгуур	Хаалга хэлбэрийн завсрыйн тулгуур	II хэлбэрийн завсрыйн тулгуур
Огт лол			
Онц лог	<ul style="list-style-type: none"> <li>Автозам дээр эзлэх талбайг багасгах боломжтой</li> <li>Нүсэр биш сэтгэлгээ төрүүлнэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бүтээцийн доод хэсгийн зайн ашиглах боломжтой</li> <li>Доогуурх автозамыг өргөтгөх боломжгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Автозам дээр эзлэх талбай хэт том</li> <li>Битүү огтлолтой тул өнгө үзэмжид сөрөгөөр нөлөөлнө</li> </ul>
Санал	Гүүрийн байгууламж төлөвлөгдсөн ихэнх хэсгүүд хотын төвд байгаа тул барилгын ажил хялбар, хвтозам дээр эзлэх талбай багатай Т хэлбэрийн энгийн хийцийг санал болгож байна.		

## (6) Метроны буудлын хийцийн төлөвлөлт




Анги лал	Салангид зорчих тавцантай	Салангид зорчих тавцан + туслах зам төмөр	Аралан зорчих тавцантай
Огт лол			
Онц лог	<ul style="list-style-type: none"> <li>Голд байрлах баганын хэсэгт машинаас ирэх ачаалал төвлөрнө</li> <li>Баганын хэсгийн зайн ашиглах боломжгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ослын үед хэрэглэх зам төмрийг зорчих тавцангийн 2 талд төлөвлөх</li> <li>Өргөн бүтээц тул завсрыйн тулгуур 2-ыг суурилуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Машинаас ирэх ачааллыг хайрцган бүтээцээр дамжуулан хүлээн авна</li> <li>Сул орон зайн их</li> <li>Зуурмагт төмөр материалыг суулган бэхжүүлэх барилгын аргыг хэрэглэх</li> </ul>
Төлөв лөлт	МЕТРОНЫ ШУГАМ -1 : 2 газар МЕТРОНЫ ШУГАМ -2 : 1 газар	МЕТРОНЫ ШУГАМ -1 : 2 газар МЕТРОНЫ ШУГАМ -2 : 1 газар	МЕТРОНЫ ШУГАМ -1 : 5 газар МЕТРОНЫ ШУГАМ -2 : 2 газар

Ангилал	Метроны буудлын дэвсгэр зураг
Салангид зорчих тавцантай	
Салангид зорчих тавцан+туслах зам төмөр	
Аралан зорчих тавцантай	



## (7) Суурийн хийц төлөвлөлт

Ангилал	Шууд суурь	Ган гадаст суурь	Барилгын талбайд цутгах гадаст суурь
Огт лол			
Онцлог	<ul style="list-style-type: none"> <li>Хөрсний тулах давхарга нимгэн үед хэрэглэдэг</li> <li>Бусад суурьтай харьцуулахад бат бөх, хэвгажилтын хэмжээ бага</li> <li>Хөрсний тулах давхарга гүнд байрлаж, хөрсний усны түвшин өндөр байвал төлөвлөх нь зохимжгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Захын ба булангийн хэсэгт тулах хүч их байх тохиолдолд төлөвлөх</li> <li>Хагарал, гэмтлээс хамгаалах болон тээвэрлэх боломжтой</li> <li>Ган төмрийг зэврэлтээс хамгаалх аргачлал хэрэгтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Материал нийлүүлэлт хэрэгтэй, үнэ хямд</li> <li>Суурь болон ган гадастай тул бүтээцийн бат бөх байдал, тогтвржилтыг сайжруулах боломжтой</li> <li>Радиус томтой гадас суурилуулах боломжтой</li> </ul>
Дүгнэлт	<ul style="list-style-type: none"> <li>Гүүрийн байгууламж төлөвлөгдөх хэсгийн ихэнх нь хэтийн төв автозамыг тусгаарлах зурvas дээр тул гадасны тоо цөөн, барилгын ажил хялбар, материалын олдоц зэргийг харгалзан барилгын талбайд цутгалтын ажил хийгддэг гадаст суурийг төлөвлөв</li> </ul>		

## (8) Метроны буудлын хийцийн төлөвлөлт

Ангилал	1 баганат ган бетон жаазан суурь	2 баганат RC жаазан суурь	3 баганат RC жаазан суурь
Огтлог			
Онцлог	<ul style="list-style-type: none"> <li>Энэ хэлбэрийн метроны буудал нь нарийн тул ойр орчмын гэрлийг халхлахгүй</li> <li>Доогуурх орон зайд ашиглах боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Метроны буудлын хэсгийн хайрцган бүтээц нь автозамыг нарны гэрлээс халхлана</li> <li>Зорчигчдын хөтөч шугам төлөвлөх боломжгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Автозам болон голын хэсэгт төлөвлөх боломжгүй</li> <li>3 баганатай тул метроны буудлын доогуурх орон зайдын ашиглалт хязгаартай</li> </ul>
Дүгнэлт	<ul style="list-style-type: none"> <li>Багана, дам нурууг хөшүүн холболтоор хийдэг жаазан гүүрийн бүтээцийг засвар үйлчилгээг хөнгөвчлөх зорилгоор тулах төхөөрөмжгүйгээр төлөвлөх нь тохирмжтой гэж үзлээ</li> <li>Автозам болон голыг хөндлөн гарах хэсгийн метроны буудлын хийц нь 1 баганат бүтээц байх нь тохиромжтой</li> </ul>		

## (9) Барилгын ажлын үеийн автозамын түгжрэлээс сэргийлэх арга

Ангилал	Гүүрийн суурийн барилгын ажил	
	Газар доорх инженерийн шугам сүлжээгүй хэсэгт	Газар доорх инженерийн шугам сүлжээтэй хэсэгт
Огтлог		
Онцлог	<ul style="list-style-type: none"> <li>Гүүрийн суурийн ажлын үед өргөн ухмалтай тул автозамын хөдөлгөөнд саад учруулна (15 м-ээс дээш хэмжээний зайд эзлэх)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гүүрийн суурийн барилгын ажлын үед бетон цутгалтын аргыг хэрэглэснээр автозам дээр эзлэх талбай багасна (2.5 м орчим зайд эзлэх)</li> </ul>

## (10) Гүүрийн явах ангийн барилгын ажлын арга

Ангилал	Кранаар түр байгууламж угсрах (Бетонон түр байгууламжийн арга)	F.S.M (Precast Span Method)
Зураг		
Онцлог	<ul style="list-style-type: none"> <li>Алгасалын түр байгууламж барьснаар барилгын ажлын хугацааг богиносгоно.</li> <li>(Замын хөдөлгөөнд учруулах саад багасгах)</li> <li>Хялбар технологитой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гүүрийн явах ангийг барих үед тулгуур ашиглана.</li> <li>Барилгын ажлын үед доогуурх зам ашиглагдана</li> </ul>
Дүг нэлт	<ul style="list-style-type: none"> <li>Автозамын тусгаарлах зурvas ба орон сууцны дүүрэгт барилгын ажлыг гүйцэтгэх тул барилгын ажлын хугацаа багатай хувилбар болох бетонон түр байгууламжийн аргыг хэрэглэнэ.</li> </ul>	

#### 4.13 Тунелын байгууламжийн төлөвлөлт

##### (1) Үндсэн хандлага

Төлөвлөлтийн чиглэл	·Тунелийн огтлолыг аль болох жижиг байхаар төлөвлөх, хөрсний нөхцлийг харгалзан газар шорооны ажлын аргыг боловсруулах
Тогтвортжилт	·Зөөлөн хөрстэй хэсэгт тоон анализ хийх, ус тусгаарлалт болон хөрс бэхэлгээ хийснээр тогтвортжилтыг сайжруулах
Барилгын ажлын байдал	·Хөрсний нөхцлийг харгалзан ухмалын ажлыг хийх аргачлалыг сонгох, барилгын ажлыг гүйцэтгэхэд хялбар байдлыг харгалзан машин механизмыг сонгох
Эдийн засгийн байдал	·Хамгийн бага огтлолтой тунелын сонголтыг хийснээр эдийн засгийн хувьд хэмнэлтийг нэмэгдүүлэх ба эдийн засгийн үнэ цэнийг дээшлүүлэх барилгын аргачлалыг ашиглах
Хүрээлэн буй орчны байдал	·Чичирхийлэл, дуу чимээ багатай тэсэлгээний ажил төлөвлөх, барилгын ажлын үед хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөллөөс хамгаалах байгууламж суурилуулах
Засвар үйлчилгээ	·Ашиглалтын үеийн засвар үйлчилгээний системчилсэн байгууламжийг бий болгох, техникийн үзлэг шалгалт хийх дугуй тунелыг суурилуулснаар засвар үйлчилгээний орон зайнг нэмэгдүүлэх

##### (2) Огтлол төлөвлөлт

Ангилал	З зам төмөрт хэлбэр	Цахилгааны шугамт хэлбэр
Огтлол		
Огтлолын талбай	56.64m <sup>2</sup>	62.64m <sup>2</sup>
Онцлог	·Огтлолын талбай бага, ослын үед дайжин зугтах боломжийн хувьд ердийн ·Засвар үйлчилгээ, эдийн засгийн хэмнэлтийн хувьд сайн	·Огтлолын талбай том, ослын үед дайжин зугтах боломжийн хувьд сайн ·Засвар үйлчилгээ болон эдийн засгийн хувьд тохиромжгүй

##### (3) Зураг төсөлд тусгах гол зүйлс, тооцооны дүн

Тунелийн огтлол	Хөрсний судалгаа	Ухмалын арга
Машин механизмын овор хэмжээнд тохирсон тунелын огтлолыг сонгох	Өрөмдлөгийн ажил болон геологийн хайгуул зэрэг нарийвчилсан судалгааг хийх	Хөрсний нөхцлийг харгалзсан ухмалын аргыг сонгох
Судалгааны дүн	·Ихэнх хэсэг нь элсэн шороон давхаргаар дайран өнгөрөх тунелын газар шорооны ажлын зардал өндөр ·Газар дор гүнд байрлах тунелын метроны буудал, агааржуулах хэсгийн түр байгууламжийн зардлаас болж барилгын ажлын өртөг өндөр байдаг. ·Барилгын ажил гүйцэтгэхэд хүндрэлтэй, эдийн засгийн үр ашиггүй байдлыг харгалзан газрын гүнд тунелын бүтээцийг аль болох төлөвлөхгүй байх нь зүйтэй.	

#### 4.14 Зам төмөр

##### (1) Үндсэн чиглэл

- Хайрган хөрсөн дээр зам төмөрийг байрлуулах нь барилгын анхан шатны зардалыг нилээд хэмжээгээр хэмнэх ба уян хатан чанар сайтай бөгөөд төмөр замыг засварлахад хялбар, газар шорооны ажил болон вагон депогийн хайрган хөрсийг төлөвлөө.
